

УУРХАЙ ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

Т.Навч
Магистр, МУИС, ЭЗС,
ХАССТ-ийн багш/судлаач

Монгол улсад албан ёсоор болон албан бусаар, хувиараа ашигт малтмал олборлох явдал сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж байна. Алт, нүүрс, жонш олборлодог олон уурхайнууд тодорхой шалтгаануудын улмаас хаагдаж үйл ажиллагаагаа явуулахгүй болсон эсвэл зарим ордын нөөц дууссаны улмаас олборлолтоо зогсоосон ил уурхайнууд олноороо бий болжээ. Энэхүү нөхцөл байдалтай уялдан Монгол улсын өрхийн нэлээд хэсэг нь хууль бусаар алт, нүүрс жонш гэх мэт ашигт малтмал олборлон амьжиргаагаа залгуулж байгаа нь олон хүмүүс, байгууллагын анхаарлыг зүй ёсоор татах боллоо.

Энэхүү олборлох үйл ажиллагааны хамгийн гол гогцоо асуудал бол ашигт малтмалыг ямар технологиор олборлож байгаа, байгаль орчинд болон хувь хүмүүсийн эрүүл мэнд, амь нас түүнчлэн өрхийн амьжиргаанд хэр зэрэг нөлөөлөл үзүүлж байгаа зэрэг асуудлууд юм. Энэ судалгаанд, хүн амын хамгийн эмзэг хэсгийн нэг болох хүүхэд, түүний уурхай дахь хөдөлмөр эрхлэлтийн талаар авч үзсэн бөгөөд энэ нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишигүй хэлбэрт ордог ажээ. Судлаач ОУХБ-ын захиалгаар МУИС-ийн ХАССТ-ийн гүйцэтгэсэн болон бусад байгууллага, судлаачдын хийсэн Уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудын үр дүнг та бүхэнд хураангуйлан хүргэж, хүүхдийн хөдөлмөр, эрүүл мэнд, амьжиргаа зэрэг олон талт асуудлаар тодорхой дүгнэлт, санал, зөвлөмжийг дэвшүүлэн тавьсан болно.

Монгол улсын эдийн засгийн хөгжлийн нэг бүрэлдэхүүн хэсэн нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаа юм. Ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хайгуулын болон ашиглалтын олон тооны лицензийг шинээр олгож, тэнд олборлох, хайгуул хийх үйл ажиллагаа хэрэгжиж байна. Жишээлбэл бүртгэлтэй буюу албан ёсоор алт олборлолтыг байршилын хувьд авч үзвэл Төв аймгийн Заамар, Багахангай сум (40 орчим уурхай), Сэлэнгэ аймгийн Баруун-Хараа, Зүүн-Хараа, Ерөө сум болон Өвөрхангай, Баянхонгор аймгуудын зарим сүмдад зонхилон байрлаж байна. Жоншны уурхайнууд Хэнтий, Дорнговь аймгуудад төвлөрч байна.

Албан ёсны олборлолтоос гадна албан бусаар ашигт малтмал хувиараа олборлох үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд улам нэмэгдсээр байна. Алт, нүүрс, жонш олборлодог олон уурхайнууд тодорхой шалтгаануудын улмаас хаагдаж үйл ажиллагаагаа явуулахгүй болсон, эсвэл зарим ордын нөөц дууссаны улмаас олборлолт зогсоосон ил уурхайнууд олноороо бий болжээ. Энэхүү нөхцөл байдалтай уялдан Монгол улсын өрхийн нэлээд хэсэг нь хууль бусаар алт, нүүрс жонш гэх мэт ашигт малтмалын орлогоор амьжиргааны гол эх үүсвэрээ болгож байгаа нь нэгэнт тодорхой болоод байна.

Энэхүү үйл ажиллагааны хамгийн гол гогцоо асуудал бол ашигт малтмалыг ямар технологиор олборлож байгаа, байгаль орчинд болон хувь хүмүүсийн эрүүл мэнд, амь нас түүнчлэн өрхийн амьжиргаанд хэр зэрэг нөлөөлөл үзүүлж

байгаа зэрэг асуудлууд юм. Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах баримт бичиг Монгол улсад өнөөдрийг хүртэл гараагүй байгаа бөгөөд тэдгээр ажлын талбаруудад хүний үндсэн эрх тодорхой хэмжээгээр зөрчигдэж байгаа нь энэ талаарх судалгаануудын явцад ажиглагдлаа. Хамгийн их сэтгэл өмзэглүүлсэн асуудал бол хувиараа ашигт малтмал олборлож буй газарт хүүхэд хүнд хүчир хөдөлмөр эрхэлж, энэхүү аюултай хөдөлмөрийн сөрөг үр дагавар, эрсдэлийг ихэсгэж байгаа явдал юм.

Ер нь албан ёсоор үйл ажиллагаа эрхэлж байгаа уурхайнуудын хувьд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр бараг гардаггүй гэх бөгөөд үүнийг баталгаажуулах тоо баримт тийм ч бэлэн бус байна. Харин хувиараа олборлож байгаа хэсэгт хүүхдийн хөдөлмөрийн энэхүү тэвчишгүй хэлбэр газар авч байгаа бөгөөд ялангуяа алт, нүүрсний орхигдсон ордууд болон албан ёсоор ажиллаж байгаа ордуудын түр ажиллахгүй байгаа улирлуудад хууль бусаар олборлох ажил нэлээд эрчимтэй явагдаж байна.

МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудад алт олборлож байгаа хүүхдүүдийн байдалд хийсэн судалгаанаас үзэхэд, алтны уурхайд хүүхэд аюултай хүнд хөдөлмөр эрхэлж байгаа байдал бодит үзэгдэл болжээ.

Хүүхдүүд алтны шороон болон үндсэн ордод /газар дор/ ажиллаж байна. Улаанбаатарын Налайх дүүрэгт хүүхдүүд газар дор нүүрс ухах, зөөх, нүүрс шигших, нүүрсний хаягдал түүх зэрэг амь нас болон эрүүл мэндэд нь эрсдэлтэй хөдөлмөр эрхэлж байна. Налайх дүүрэгт 100-аад хүүхэд байнга уурхайд ажилладаг ба энэ тоонд, уурхайн гадуур нүүрс түүж зардаг бага насны хүүхдүүд, мөн сургуульд явангаа ажилладаг хүүхдүүдийг оруулаагүй болно. Налайхын уурхайд нэг хүүхэд хорт хийнд хордож нас барсан тохиолдол ч шинээр гарч ирлээ.

Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд дахь алтны үндсэн ба шороон ордод ажиллаж байгаа хүүхдүүдийн судалгаагаар, наад зах нь эдгээр газруудад 1871 хүүхэд алт олборлодог гэсэн дүн гарсан. Байршилаар авч үзвэл, Сэлэнгэ аймагт алтны 18, Дархан-Уул аймагт алтны 19, Төв аймгийн алтны 5 ордод хүүхдүүд ажиллаж байна. Түүнчлэн Дорноговь, Хэнтий аймгуудад холбогдох байгууллагын зүгээс хийсэн ажиглалтаас үзэхэд нэг талаас орон нутгийн ажилгүйчүүд ажил эрхэлж орлого олох шаардлагын улмаас, нөгөө талаас зарим жоншны уурхайнуудын техникийн хүчин чадал муудсанаас шалтгаалан уурхайнууд хаагдаж, хувиараа жонш олборлох явдлыг дэмжиж байгаагаас үүдэн албан бусаар жонш олборлох явдал улам түгээмэл болж байгаа ажээ. Үүнээс гадна ашигт малтмалын лиценз авсан байгууллагууд лицензийнхээ талбайд орон нутгийн иргэдийг ажиллуулахыг зөвшөөрч тэднээс жонш худалдан авах нь эрс нэмэгдсэн нь дээрх үйл ажиллагааг дэвэргэх нөхцөл болж байна. Эндээс, хүүхэд эцэг эхийнхээ хамт ажиллаж эхлэх эрсдэл улам нэмэгдэж байна. Ийнхүү, хүүхдийн хүнд хүчир хөдөлмөр эрхлэлт гаражгүй гэх магадлал тун бага байгааг сонордуулах нь зүйтэй болов уу.

Судалгаанаас үзэхэд алт болон нүүрсний уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн 34-41 хувь нь сургууль завсардсан хүүхдүүд байна. Үүний зэрэгцээ сургуульд сурдаг хүүхдүүд ч орлого олох зорилгоор ажилладаг болох нь харагдлаа. Сургууль завсардсан хүүхдүүдийн дийлэнх нь 5-р ангиасаа сургуулиас гарсан байна. Тэдний сургууль завсардсан шалтгаан нь бага ангийн хүүхдүүдийн хувьд сурах бичиг, хувцасны зардал өндөр учраас, харин дунд (5-8) болон ахлах (9-10)

ангийн хүүхдүүд голдуу суралцах сонирхолгүй, сурлага муу, өрхийн орлогод тус нэмэр оруулах зорилгоор сургуулиас гарчээ.

Алт, нүүрс олборлодог өрхүүдийн талаас илүү хувь нь орлогын тогтмол эх үүсвэргүй өрхүүд байлаа. Энэ үйл ажиллагаанд өрхөөрөө оролцох нь түгээмэл үзэгдэл болжээ. Алт олборлож байгаа өрхүүдийн 80 орчим хувь нь энэ ажлыг 5-7 жилийн өмнөөс эхлэн өрхэлж байгаа бөгөөд үлдсэн 20 гаруй хувь нь түүнээс дээш жил ажиллаж байгаа нь судалгаанаас ажиглагдлаа. Харин алт олборлож байгаа өрхөд байгаа 6-18 насны хүүхдүүдийн 53.6 хувь нь байнга алт олборлодог гэсэн үр дүн судалгаанаас харагдсан юм.

Алт, нүүрс олборлох ажил хүнд, тэр тусмаа хүүхдэд бүр аюултай, эрсдэлтэй ажил гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ эрүүл мэндэд учирсан хохирлын талаар дараах мэдээллийг бидэнд өгсөн юм. Давхардсан тоогоор хүүхдүүдийн 43.3 хувь нь амьсгалын замын өвчин байнга тусдаг, 41.7 хувь нь бөөр шээсний замын өвчтэй, 25.0 хувь нь үе мөч нурууны өвчтэй, 23.3 хувь нь нүдний хараа, чих хамар хоолойн согогтой, 20.0 хувь нь механик гэмтэл авсан, 10.0 хувь нь зурхний өвчтэй, ядаргаатай болсон, 3.3 хувь нь биеээр юм туурч, үс халцрах тохиолдол гарсан байна. Түүнээс гадна үндсэн ордоос алт олборлох үед түлэгдэх явдал нэлээд гардаг байна. Харин Налайхын уурхайн хувьд хүүхдүүд өөрсдийгээ эрүүл гэж дүгнэж байсан боловч эмнэлэгийн үзлэгээр нийт хүүхдүүдийн 75.7 хувь нь бөөрний, 21.6 хувь нь үе мөч нурууны, 48 хувь нь уушигны өвчтэй байсан байна.

Алт олборлох явцад гардаг нэг ноцтой асуудал бол эцэг, эхчүүд хүүхдүүдээрээ мөнгөн ус бариулах явдал байлаа. Тэд хэдийгээр мөнгөн усны хорын талаар хагас дутуу ойлголттой байгаа боловч энэ ажлыг амьжиргааны эрхээр хийхээс өөр аргагүйд хүрдэг байна. Үүнээс харахад энэ аюултай, хортой ажлын талаар хүмүүст бүрэн, гүйцэд ойлгуулах, сурталчлах нь ирээдүйг нь аврах нэн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Албан бусаар алт, нүүрс олборлож байгаа хүмүүсийг энэ ажлаас хөндийрүүлж, өөр ямар арга замаар тэдний амьдрал ахуйг дээшлүүлж болох талаар хариулагчдын санал бодлыг тодруулахад, дийлэнх нь ажлын байр байвал цаашид хууль бусаар алт, нүүрс олборлох шаардлагагүй гэж үзэж байсан төдийгүй хувиараа үйлдвэрлэл явуулах, наймаа хийх, мал аж ахуй, газар тариалан эрхлэхээс гадна хүүхдүүдээ боловсрол, мэргэжилтэй, ажилтай болговол амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой болно гэж хариулж байлаа.

Хувиараа алт, нүүрс олборлох ажилд оролцсон хүүхдүүдийн насны байдлыг авч үзвэл анх уг ажлыг хийж эхэлсэн дундаж нас 12.2, харин одоо ажиллаж буй хүүхдүүдийн дундаж нас нь 14 байлаа.

Хүүхдийн эрхэлж байгаа хөдөлмөр нь: алтны уурхайд шороо зөөх, алт угаах, нүх ухах, чулуу, бутлах, мөнгөн ус бариулах зэрэг хүнд болон аюултай ажлууд байгаа бол нүүрсний уурхайн хувьд галт тэрэгнээс унасан нүүрс түүх, нүүрс ухах, нүүрс үүрэх, борлуулах зэрэг хүнд хүчир ажлууд байдаг ажээ. Нүүрс ухах ажлыг хүүхдүүд ихэвчлэн өвлүүн улиралд хийдэг. Учир нь зуны улиралд нүүрс борлуулалтгүй, газар гэссэн үед нуранги ихтэй байдаг юм байна. Нүүрс ухах ажлыг хүүхдүүд 8-10 метрийн гүнд, 30-150 метрийн урттай нүхнээс олборлодог ба ойролцоогоор 50 кг ачааг энэ газраас үргэлж зөөдөгбайна. Харин жижиг хүүхдүүд ихэвчлэн гадуур байгаа нүүрсийг түүдэг юм байна. Судалгааны явцад,

хүнд нүүрс байнга үүрдгээс шалтгаалан хүүхдүүд жижиг биетэй, давжaa болсон нь цөөнгүй ажиглагдлаа.

Хувиараа алт олборлож буй хүүхдүүдийн өдөрт ажиллаж буй дундаж хугацааг улирлаар авч үзвэл зуны улиралд дунджаар 9 цаг ажилладаг бол хавар, намрын улиралд 5-6 цаг, харин өвөл 4 цаг ажилладаг бол харин нүүрсний уурхайд хүүхдүүд ихэвчлэн өвлүүн улиралд өдөрт 10 орчим цаг ажилладаг байна.

Алт олборлож буй болон нүүрсний уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд хамгийн их тохиолддог бэрхшээл нь өлсөж ядрах, гэмтэж бэртэх, хөлдөж, даарах зэрэг явдал ажээ.

Алтнаас олсон орлого гэрийнхнийх нь амьдрал ахуйд хэрхэн нөлөөлдөг талаар хүүхдүүдийн өөрсдийн санал бодлыг асуухад тавны нэг орчим нь өөрийн олж буй орлогыг өрхийнхөө орлогын гол эх үүсвэр гэж үзэж байв.

Судалгааны явцад ашигт малтмал олборлодог газарт охид биеэ үнэлж орлого олох явдал цөөнгүй байдаг тухай хүмүүс мэдээлж байсан нь сэтгэл эмзэглүүлсэн асуудлын нэг мөн гэж үзэж байна.

Уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн осолдсон байдал, түүний шалтгааныг тодруулбал судалгаанд хамрагдсан алт олборлож буй хүүхдүүдийн 22.5 хувь нь осолд орж байсан ба давхардсан тоогоор хүүхдүүдийн 92.6 хувь нь хөл гар, нуруугаа, 14.8 хувь нь тархи толгойгоо гэмтээж байсан боловч, ердөө дөрөвний нэг нь эмнэлэгт хандсан байна.

Ашигт малтмал олборлох явцад нэг талаар албан бусаар, өөрөөр хэлбэл хулгайн замаар өрхүүд алт олборлож байгаагаас харуул, хамгаалалт болон хууль сахиулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Нөгөө талаас хууль сахиулах байгууллагын ажилтан, цагдаа, харуул хамгаалалтынханд өөрсдийн эрх, үүргийг хэтрүүлэх тохиолдол элбэг байдаг талаар яригдаж байв. Жишээлбэл, бидний сонгосон объектед албан бусаар алт олборлож байгаа хүмүүсийн боловсролын түвшин доогуур, амьжиргаа ядуу байгаагаас торгуульь ноогдуулахад эргээд албан ёсны санхүүгийн баримт шаардаж мэддэггүй, тодорхой хугацаагаар saatuuulagdaj байхдаа зодуулах, олсон алтаа хураалгах, эд зүйлсээ эвдүүлэх, хэл амаар доромжуулах зэргээр дарамтуулдаг байна. Түүнчлэн хууль бусаар алт олборлож буй хүүхдүүдийн 58.2 хувь цагдаа, уурхайн харуул хамгаалалтын ажилтнуудад баригдаж байсан байна. Тэдгээрийн 44.4 хувь нь зүй бусаар хүч хэрэглүүлж шийтгүүлсэн гэж хариулсан нь шийтгэлийн бусад хэлбэрүүдээс хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна. Үүнээс гадна хүүхдүүдийн 31.9 хувь нь цагдаа нарын хувцас угаах, ажлын байр, өрөөг цэвэрлэх, хог түүх, түлээ мод хагалах, ус зөөх зэргээр шүүхийн ямар нэг шийдвэргүйгээр ажил хийлгэдэг гэж хариулсан байна.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 60 гаруй хувь нь мөнгө олдог учраас энэ ажилдаа дуртай байдаг гэсэн ба ялангуяа бага насын хүүхдүүдтэй ярилцаж байхад энэ ажил тэдэнд илүү зугаатай, гоё санагддаг учраас хийдэг хэмээн ярьсан юм.

Дээрх нөхцөл байдлаас үндэслэн асуудлыг тодорхой түвшинд нь шийдвэрлэх зайлшгүй шаардлага гараад байна.

Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд:

Хувиараа алт, нүүрс олборлох ажил, ялангуяа энд ажил хийж буй хүүхдүүдийн хувийн жин өндөр байгаа нь Монгол орон дахь ядуурал, ажилгүйдэлтэй шууд холбоотой юм. Иймд гэр бүл, олон нийт, засаг захиргаа, хууль эрх зүйн хүрээнд авч хэрэгжүүлж болох дараах цогц үйл ажиллагааны чиглэлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Хүүхдүүдийг ашигт малтмал олборлох аюултай, амь дүйсэн, эрсдэл ихтэй ажлаас хөндийрүүлэх талаар зохиох ажлыг түргэвчилж, улсын хэмжээний хөтөлбөр гарган үе шаттайгаар хэрэгжүүлэх;
2. Хүнд аюултай нөхцөлд уурхайд ажиллаж буй хүүхдүүдийг ажлаас нь хөндийрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ, хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагааг хүүхдийг нийгмийн үйлчилгээнд хамруулах ба гэр бүлийнх нь орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлэх
3. Хувиараа алт, нүүрс, жонш олборлох ажилд хууль эрх зүйн талаас нь зохицуулалт хийж, хуулийн хүрээнд албан бус уурхайд насанд хүрээгүй хүүхэд ажиллахыг зогсоох талаар арга хэмжээ авах;
4. Алт, нүүрс олборлож байгаа цэгүүдэд иргэд, цагдаа нарын хооронд үүсч буй зөрчил, түүнээс үүдэлтэй үр дагаврыг арилгах ажлыг хүчний байгууллагын зүгээс анхаарч, орон нутгийн хяналтыг өндөржүүлэх;
5. Мөнгөн устай харьцан ажилладаг обьектуудад хүмүүсийн мөнгөн уснаас хордолтын түвшин, хамрах хүрээг судлаж, мөнгөн усны аюулын талаар нийт ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийн бүх сувгаар өргөн сурталчлах ажлыг зохион байгуулах;
6. Алт, нүүрс олборлож буй нутаг дэвсгэрт ажлын байр нэмэгдүүлэх талаар аймаг, сумдын засаг захиргаа болон төр, засгийн холбогдох албадын үйл ажиллагааг идэвхжүүлж, онцгой анхаарал тавих;
7. Өрхийн жижиг аж ахуй хөгжүүлэхдэд онцгой анхаарах.
8. Байгаль орчны тэнцвэрт харьцааг алдагдуулахгүй байх үүднээс ашигт малтмал олборлож байгаа газруудад нөхөн сэргээлт хийх
9. Ашигт малтмал олборлолтын ажлыг лицензлүүлэх талаар яаралтай арга хэмжээ авах
10. Ашигт малтмал олборлох талаар гарсан хууль тогтоомжинд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар хуулийн тодорхой заалтуудыг оруулж өгөх
11. Орон нутагт ажиллаж байгаа хөдөлмөрийн хяналтын байцаагчдад ашигт малтмал олборлож буй иргэд, хүүхдийн талаарх мэдээлэл, хөдөлмөрийн нөхцөл, зохицуулалтын талаарх асуудлуудыг хариуцуулах, хяналтыг сайжруулах.

Ном зүй:

1. Алт олборлогч хүүхдүүдийн талаарх судалгаа, (ОУХБ-ын АЙПЕК-ийн санхүүжүүлэлтээр, МУИС-ийн ХАССТ, 2002 он)
2. Налайх дүүрэгт нүүрс олборлож байгаа хүүхдүүдийн талаарх судалгаа (МЭХ-ны жижиг судалгаа, 2000 он)